*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын*
*2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралт*

# АРВАЙХЭЭР СУМЫН ӨЛЗИЙТ 4 ДҮГЭЭР БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ ШИЙРЭВГЯМЦАЙН БОЛОРЧУЛУУНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин, биелэлт | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. "Хууль тогтоомж, бодлого шийдвэрийг анхан шатанд хэрэгжүүлж, иргэд олон нийтэд сурталчлан ажиллах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, иргэдэд хууль эрх зүйн сургалт, зөвлөгөө өгөх<br><br>*/АБТодорхойлолт 1.1 дэх заалт/* | Зөвлөгөө, мэдээлэл өгсөн хүний тоогоор | 600 | 800 | Тайлант онд 1056 иргэнд эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Багаас зохион байгуулсан 4 удаагийн сургалтад хамрагдсан 248, Авлигын эсрэг өдрийн хүрээнд 120, багийн ажлын албаар үйлчлүүлсэн 698 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.<br>Зөвлөгөө мэдээллийг агуулгаар нь ангилбал:<br>Нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр 188, хоршоо хөгжүүлэх сангийн зээл, малчны зээл, ипотекийн зээлтэй авахтай холбоотой 140, цагдаагийн байгууллага, ШШГБайгууллага, шүүхэд нэхэмжлэл гаргахтай холбоотой 124, иргэний улсын бүртгэлтэй холбоотой 58, газар өмчлөх, эзэмшихтэй холбоотой 13, бусад асуудлаар 175, Авлигын эсрэг хууль тогтоомж болон E-mongolia, E-kids, "Эрсдэлгүй Өвөрхангай" аппликейшн, "What3words" аппликейшн ашиглах заавар зэргийг 248 иргэнд өгсөн байна. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг танхимаар болон цахимаар зохион | Цахим:<br>Танхим: | 4 | **Цахим мэдээлэл: 4, нийт хандалт 432**<br>ОНХС-ийн цахим санал өгөх заавар<br>Цахим орчны аюулгүй байдал<br>Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга<br>Хүүхэд хамгааллын тухай хууль<br>**Танхимын сургалт: 5, хамрагдсан 272 иргэн**<br>1. 04 сарын 9-нд өдөр "Эрүүгийн хууль"-ийн тусгай ангийн 17 дугаар бүлэг, 17.1 дэх заалтаар хэрэг зөрчилд | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулсан тоогоор | | | холбогдсон 9 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, хуулийн холбогдох заалтуудаар гарын авлага боловсруулж, мэдээлэл өгсөн.<br>2. 05 сарын 31-нд “Хүүхэд байх хөөрхөн” өдөрлөг, сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд<br>- “Хогоо хогийн саванд хаяж хэвшээрэй”<br>- “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” сургалт, мэдээллийг хийж, зорилтот бүлгийн 75 хүүхэд 32 эцэг эхийг хамруулсан. Хамтарсан багаас “Зуны амралтаа зугаатай өнгөрүүлээрэй” хүүхэд хамгааллын зөвлөмжийг бэлтгэн 50 ширхгийг тараасан.<br>3. 11 сарын 13-нд “Цахимаар үйлчлүүлж, цагаа хэмнэе” сургалтыг багийн ахмадын баярын арга хэмжээнд хүрэлцэн ирсэн 89 ахмадад хийж, 7 ахмад настны гар утсанд emongolia аппликейшн суулгаж, 32 ахмадын гар утсанд Эрсдэлгүй Өвөрхангай, 3 үгт хаяг аппликейшн суулгаж өгсөн.<br>4. 11 сарын 20-нд иргэдийн цахим ур чадварыг сайжруулах зорилтот сургалтыг зохион байгуулж, ХБИ, малчин, ахмад настан, хэсгийн ахлагч нийт 39 иргэн хамрагдсан.<br>- Төрийн цахим үйлчилгээ ба цахим орчны аюулгүй зөв хэрэглээ,<br>-Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулга,<br>- Хог хаягдлын тухай хууль,<br>- Багийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим заалтаар сургалт, мэдээлэл хийж, гарын авлага тараасан.<br>5. 11 сарын 20-нд Дэлхийн хүүхдийн өдөрт зориулсан “Найз байя” нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 10 дугаар ангийн 28 сурагч, анги удирдсан багшийн хамт хамрагдсан. Уг сургалтаар “Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүй, эерэг хандлага” сэдвээр сэтгэлзүйч Т.Юмжирдулам, Электрон тамхины хор уршиг сэдвээр Түшиг дэлгээн ӨЭМТ-ийн НЭМА н.Цэвэлмаа, Зөрчлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн холбогдох заалтаар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Багийн цагдаа А.Эрдэнэцогт нарыг урьж, сургалт мэдээлэл өгч, сэтгэл заслын тест ажилласан. | | |
| | | Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2 нэр төрлийн хуулийн сургалт сурталчилгаа, гарын авлага бэлтгэн боловсруулсан тоогоор | 4 | 4-өөс доошгүй материал бэлтгэж, 500-аас доошгүй иргэнд түгээсэн байна | 10 төрлийн гарын авлага бэлтгэж, давхардсан тоогоор 580 иргэнд түгээсэн. Тухайлбал:<br>✓ ОНХС-ийн саналыг цахимаар өгөх заавар 60,<br>✓ Авлигийн эсрэг хууль тогтоомж 80,<br>✓ Эрсдэлгүй Өвөрхангай апп-ны танилцуулга 60,<br>✓ Цахим төрийн үйлчилгээ цахимд шилжсэнээс гарын авлага 8 хуудас, 13 нүүртэй /мод тарих зөвлөмж, ОНХС-ийн санал өгөх, 3 үгт хаяг, ЭӨ, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй, Хариуцлагатай иргэн байя, Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлт, Угийн бичиг хөтлөх арга, шаардлагатай утасны жагсаалт зэрэг мэдээлэлтэй/ 60,<br>✓ Цахим хөгжлийг түгээгч танд баярлалаа гарын авлага 8 хуудас, 13 нүүртэй /emongolia go-Uvurkhangai, Соёл танаас эхэлнэ, цахим орчны аюулгүй зөв хэрэглээ, үл хайхрах хүчирхийлэл, хүүхдийг ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлье, 3 үгт хаяг, шаардлагатай утасны жагсаалт зэрэг мэдээлэлтэй/ 60<br>✓ Хүүхэд хүмүүжлийн зөрөг арга 80,<br>✓ Үе тэнгийн дээрэлхэлт, түүний хэлбэр 40<br>✓ Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга 40ш<br>✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих 40,<br>✓ Зөрчлийн тухай хууль 60 | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 1.2.** Багийн иргэдийн Нийтийн хурлын бэлтгэл ажлыг хангах, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх */АБТодорхойлолт 1.3 дахь заалт/* | Холбогдох хууль тогтоомжийн дагуу хурлын бэлтгэл ажлыг хангасан хувиар | 100 | 100 | Арвайхээр сумын Өлзийт 4 дүгээр багийн иргэдийн Нийтийн Хуралдаан тайлант хугацаанд улирал бүр хуралдаж, давхардсан тоогоор нийт 255 иргэн хуралд оролцсон. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | Хурал оролцсон | 20 | 25-аас доошгүй хувь | Хурал оролцсон иргэдийг хүйс, насны бүлгээр ангилж үзвэл эмэгтэй 157, эрэгтэй 98, насны бүлгээр авч үзвэл 19-39 насны 64, 40-49 насны 75, 50-59 насны 62, 60 дээш | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

77

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | залуучуудын хувиар | | | насны 54 иргэн байна. Хурал оролцсон залуучуудын оролцоог хувиар тооцвол 25,09% байна. | | |
| 3. | **Арга хэмжээ 1.3.** Багийн Иргэдийн Нийтийн хурлын тэмдэглэл, тогтоол шийдвэрийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу хөтлөх */АБТодорхойлолт 1.4 дэх заалт/* | Хурлаас гарсан тэмдэглэл, тогтоол шийдвэрийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулсан хувиар | 100 | 100 | Багийн иргэдийн Нийтийн Хуралдаанаас гарсан 8 тогтоол, 2 хурлын тэмдэглэлийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу хөтлөж хугацаанд нь Арвайхээр сумын ИТХурралд уламжлан, хүргүүлж ажилласан. Тус багийн ажлын алба нь 2020-2024 оны Хуралдааны баримт бичгийг стандартын дагуу боловсруулсан байдал болон хурлын ирц бүрдүүлэлтийг нэмэгдүүлсэн үзүүлэлтээр шалгарч, Монголын Нутгийн удирдлагын холбооны "Хүндэт өргөмжлөл"-өөр шагнагдсан. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 4. | **Арга хэмжээ 1.4.** Арвайхээр сумын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулах | Багийн сонгуулийн насны нийт иргэдээс цаасан маягтаар санал өгсөн иргэдийн хувиар | 10 | 15-аас доошгүй хувь | 2025 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний саналыг цаасан маягтаар 280 иргэнээс авсан. Энэ нь багийн сонгуулийн насны нийт иргэдийн 13,9 хувь байна. | 2024.01.02<br>2024.06.17 | 90 |
| | | Багийн сонгуулийн насны нийт иргэдээс цахимаар санал өгсөн иргэдийн хувиар | - | 25-аас доошгүй хувь | 2025 онд ОНХС-ийн 333 санал цахимаар авсан. Цахимаар санал өгсөн иргэдийг хүйсийн байдлаар авч үзвэл 82 нь эр, 251 нь эм байна. Цахимаар санал өгсөн иргэдийг багийн сонгуулийн насны нийт иргэдийн тоотой харьцуулбал 16,6 хувь байна. Цахим санал өмнөх оноос 261-ээр буюу 5 дахин нэмэгдсэн. | 2024.01.02<br>2024.06.17 | 90 |
| | | ОНХС-ын төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын дагуу боловсруулж, ХЗА-д | 100 | 100 | 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хуралдсан багийн иргэдийн Нийтийн 2 дугаар улирлын Хуралдаанаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал асуулгыг иргэдээс авч Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын дагуу боловсруулж, хотын Захирагчийн албанд хугацаанд нь хүлээлгэн өгсөн. | 2024.01.02<br>2024.06.17 | 100 |

78

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хугацаанд нь бүрэн хүлээлгэж өгсөн хувиар | | | | | |
| 5. | **Арга хэмжээ 1.5.** Хэсгийн ахлагчдын ажлын тайлан, мэдээг сар бүр хүлээн авч, улирал бүрээр нэгтгэн ИТХ-д хүргүүлэх | Хүргүүлсэн тайлангийн тоогоор | 4 | 4 | Хэсгийн ахлагчдын хийсэн ажлын тайланг сар бүр авч, улирал бүр нэгтгэн Санхүүгийн албанд хүргүүлсний дагуу, 20 хэсгийн ахлагчид улирал тутамд 90.000 төгрөгийн урамшуулал олгогдсон байна. | 2024.01.02 2024.12.31 | 100 |
| 6. | **Арга хэмжээ 1.6.** Багийн хэмжээнд цэргийн бүртгэлийг зохион байгуулах, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх *[АБТодорхойлолт 1.4 дэх заалт]* | Бүртгэлд хамрагдсан хувиар | 100 | 100 | 2024 оны Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлд 18-50 насны иргэдийг бүрэн хамруулж, ажилласан. Цэрэгжсэн байгууллагад ажилладаг, цэргийн жинхэнэ алба хааж байгаа, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа, тайван цагт үл тэнцэгч иргэдийг бүртгэхгүйгээр нийт 652 иргэн Emongolia цахим системээр болон биеэр ирж 100 хувь бүртгүүлсэн. Цэргийн тоо бүртгэлд хамрагдсан 652 иргэнээс 1-р зэргийн бэлтгэл офицер 4, бэлтгэл ахлагч 7, бэлтгэл байлдагч түрүүч 182, Цагдаа, ШШГ, Шүүх, Тагнуулын байгууллагад ажилладаг 8, Онцгой байдлын албанд ажилладаг 7, зэвсэгт хүчинд ажилладаг 25, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 440 байна. Тайван цагт цэргийн албанд тэнцэхгүй 22, ял эдэлж байгаа 4. | 2024.01.02 2024.02.25 | 100 |
| | | Хүргүүлсэн судалгаа, тайлангийн хувиар | 100 | 100 | Цэргийн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт орж ажиллан тоо бүртгэлтэй холбоотой мэдээ, тайлан нэгтгэлийг бүрэн гаргаж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгсөн. Тухайлбал: боломж, идэрчүүд, нийт эрчүүд зэрэг судалгааг гаргасан. Мөн шинээр 4 дүгээр багийн бэлтгэл офицер, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний чанар байдлын судалгаа буюу Тархцын судалгааг маягтын дагуу гаргаж, хүргүүлсэн. | 2024.01.02 2024.02.25 | 100 |
| 7. | **Арга хэмжээ 1.7.** Сумын дайчилгааны төлөвлөгөө, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, орон | Төлөвлөгөөний дагуу оногдуулалт хийсэн хувиар | 100 | 100 | Аймгийн дайчилгааны төлөвлөгөө, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, орон нутгийн цэргийн отрядын хүн, техникийн оногдуулалтад тодотгол хийж, аймгийн Цэргийн штабт хүлээлгэн өгсөн.<br>2024.04.01-06 хооронд Зэвсэгт хүчний 256-р ангид зохион байгуулагдсан цэргийн бэлтгэл үүрэгтний давтан | 2024.01.02 2024.02.25 | 100 |

79

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нутгийн цэргийн отрядын хүн, техникийн оногдуулалтыг хийж бэлтгэл үүрэгтний бэлэн байдлыг хангах | | | | сургалтад I зэргийн бэлтгэл үүрэгтэн Ю.Норовсүрэнг хамруулсан. | | |
| | | Гаргасан судалгааны тоогоор | 1 | 1 | Сумын дайчилгааны төлөвлөгөө, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, орон нутгийн цэргийн отрядын хүн, техникийн судалгааг хугацаанд нь гаргаж, оногдуулалтыг шинэчлэн 2 дугаар сарын 25-ны дотор аймгийн Цэргийн штабт хүлээлгэн өгсөн. | 2024.01.02 2024.02.25 | 100 |
| 8. | **Арга хэмжээ 1.8.** Багийн хэмжээнд цэрэг татлагын ажлыг зохион байгуулах *<br>/АБТодорхойлолт 1.4 дэх заалт/* | Иргэдийн хамрагдалтын хувиар | 98 | 100 | 2024 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагад биеэр нийт 126 цэрэг орохоос төгсөх курсийн 16, I курсийн 4, гадаадад сурч, ажиллаж байгаа 12 буюу нийт 32 цэрэг бичиг баримтаар, 89 цэрэг биеэр орсон, хамрагдалтын хувь 96.<br>Тус багаас ЗХ-ний 256 дугаар ангид 1, 0167 дугаар ангид 2, 326 дугаар ангид 2 цэрэг буюу нийт 5 цэрэг мордсон. | 2024.01.02 2024.11.25 | 98 |
| | | Цэргийн алба хааж буй иргэдийн ар гэрт олгох дэмжлэг, туслалцаанд хамруулсан өрхийн тоогоор | - | Шаардлагатай өрхийг хамруулсан байдлаар | 2024 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагад өөрийн хүсэлтээр татагдан 0131 дүгээр ангид алба хааж байгаа 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагаар тэнцэн 326 дугаар ангид алба хааж байгаа 1 цэргийн ар гэрт сумын Засаг даргын нөөц сангаас тус бүр 250.000 төгрөгийн түлээ, нүүрсний дэмжлэгт хамруулсан. | 2024.01.02 2024.10.25 | 100 |
| **Зорилт 2. "Багийн өрх, хүн амын статистикийн мэдээллийг зохих журмын дагуу нийтэд мэдээлж, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг ханган, удирдлагыг мэдээллээр хангах, тайлагнах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1.** Хүн ам, өрхийн мэдээллийн санг үнэн зөв хөтөлж, баяжилтыг тогтмол хийж, төрийн байгууллага, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажилласан байх *<br>/АБТодорхойлолт 2.1 дэх заалт/* | ХАӨМС-ын програмын алдааны тоогоор | - | Алдаагүй байх | Хүн ам, өрхийн мэдээллийн санг үнэн зөв хөтөлж, баяжилтыг тогтмол хийж, төрийн байгууллага, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажилласан, ХАӨМС-ийн программ алдаагүй. Мөн ХАӨМС программын нууцлалыг хангаан ажиллаж байна. | 2024.01.02 2024.12.31 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 2.2.** Багт шинээр баригдсан орон | Шинээр баригдсан орон сууцны | | | 2023 онд шинээр ашиглалтад орсон 7 сууцны байшингийн мэдээллийг ОС1, ОС3 маягтын дагуу гаргаж, Төсөв, төрийн сангийн мэргэжилтэнд хүргүүлсэн. | 2024.01.02 2024.12.31 | 100 |

80

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | суucны тооллогын мэдээг ОС1, ОС3 маягтаар гаргаж өгөх */АБТодорхойлолт 2.1 дэх заалт/* | мэдээллийг маягтын дагуу гаргаж өгсөн тоогоор | 7 | Шинээр баригдсан орон сууцны тоогоор | 2024 онд ашиглалтад орсон 12 сууцны байшинг Улсын бүртгэлтийн хэлтсийн эд хөрөнгийн бүртгэлд шинээр бүртгүүлж, гэрчилгээжүүлсэн. Багт шинээр баригдсан орон сууцны тооллогын мэдээг ОС1, ОС3 маягтаар гаргаж 2025 оны 1 дүгээр улиралд хүргүүлнэ. | | |
| 3. | **Арга хэмжээ 2.3.** Залуучуудын суурь судалгаанд баяжилт хийж шинэчилж гаргах */АБТодорхойлолт 2.3 дахь заалт/* | Гаргасан судалгааны тоогоор | 1 | 1 | Залуучуудын суурь судалгаанд тогтмол баяжилт хийж ажиллаж байна. Багийн хэмжээнд 18-34 насны 827 залуучууд байгаа бөгөөд хүйсээр нь авч үзвэл эр 419, эм 408, боловсролын түвшнээр авч үзвэл магистр 1, дээд 230, бүрэн дунд 204, мэргэжлийн 93, суурь 51, бага 21, боловсролгүй 7 иргэн байна. Ажил эрхлэлтийн байдлаар авч үзвэл төрийн байгууллагад 78, их дээд сургуулийн оюутан 81, гадаадад сурч ажиллаж байгаа байгаа 30, ЕБС-ийн сурагч 50, ажилгүй 80, ХХЭ 42, хувийн хэвшилд ажиллагч 466 гэсэн тоон үзүүлэлт гарсан. | 2024.01.02<br>2024.12.31 | 90 |
| 4. | **Арга хэмжээ 2.4.** Багт зохион байгуулсан ажил, арга хэмжээ болон бусад мэдээллийг олон нийтэд цахим хуудсанд сурталчлах */АЗД-аас СЗД-тай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 1.2.1, АБТодорхойлолт 3.3 дахь заалт/* | Багийн цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл боловсруулж иргэдэд нээлттэй сурталчилгаа хийсэн тоогоор | 12 | 12 | “Өлзийт Дөрөвдүгээр Баг” цахим хуудас, “Өлзийт 4 дүгээр багийн иргэд” групп чат, “Өлзийт 4-р баг” хаалттай групп, “Арвайхээр сумын 4-р багийн залуус” хаалттай группүүдэд цаг үеийн холбогдолтой зар мэдээлэл, ажлын байрны зар болон Арвайхээр сумын ЗДТГ цахим хуудсанд тавигдсан мэдээ, мэдээллийг нийтэлж, түгээж байна. Мөн дээрх цахим хаягуудад багийн ажлын албанаас зохион байгуулсан ажил, арга хэмжээний мэдээллийг тогтмол түгээн ажиллаж байна. Иргэдийн цахимаар мэдээлэл авах байдлыг нэмэгдүүлэх зорилгоор багийн цахим хаягийг цахим хуудас болгон тохируулсан бөгөөд 2163 дагагчтай болсон. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 5. | **Арга хэмжээ 2.5.** Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, хамран сургалтыг нэмэгдүүлэх, | Сургуулийн насны хүүхдийн хамран сургалтын хувиар | 100 | 100 | 2024-2025 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид элсэн орох 6 настай 63 хүүхдийн судалгааг гарган аймгийн Боловсролын газарт хүргүүлсэн.<br>Сургууль завсардсан сургуулийн насны 5, 18-25 хүртэлх насны 3 нийт 8 иргэний судалгааг гарган Насан туршийн боловсрол төвд хүргүүлсэн. Сургуулийн насны 5 хүүхдийн 4 нь хөгжлийн бэрхшээлтэй улмаас сургуульд хамрагдах боломжгүй байсан бол 1 нь ар гэрийн гачигдлаас шалтгаалж, сургуульд хамрагдаагүй байсан Д.Тэлмүүнийг дүйцсэн хөтөлбөрт хамруулж суурь боловсролын гэрчилгээ авсан. | 2024.09.01<br>2024.12.31 | 100 |

81

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадаагүй иргэдийг дүйцсэн хөтөлбөрт хамруулж, боловсрол эзэмшүүлэх | Цэцэрлэгийн насны хүүхдийн хамран сургалтын хувиар | 90 | 92 | Цэцэрлэгийн насны хамран сургалтыг 100 хувьд хүргэх зорилгоор 2024-2025 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдах 2-5 насны 258 хүүхдийн судалгааг гарган аймгийн Боловсролын газарт хүргүүлсэн. Цэцэрлэгт явах боломжтой ч хамрагдаж чадахгүй байсан 13 хүүхдийн судалгааг БГ-т явуулж үүнээс 8 хүүхэд нь 15 дугаар цэцэрлэгт хамрагдаад байна. Байнгын асаргаа шаардлагатай цэцэрлэгт хамрагдах боломжгүй 7, ар гэрийн байдлаас хамрагдах боломжгүй 8 буюу нийт 15 хүүхэд гэрээр хүмүүжиж байна, хамран сургалт 94 хувьтай. | 2024.09.01<br>2024.12.31 | 94 |
| 6. | **Арга хэмжээ 2.6.** Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг явуулж 3-15кВт эх үүсвэрийн мэдээллийг программд бүрэн оруулах | Судалгааг шинэчилж, хугацаанд нь алдаагүй программд оруулсан хувиар | 100 | 100 | Багийн нутаг дэвсгэрт утаа гаргаж байгаа 740 өрхийн зуухны судалгааг гарган орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан /envpol.mne.gov.mn/ программд шивж байршуулсан. Үүнээс 361 нь гэрийн яндан, 379 нь байшингийн яндан байгаа бөгөөд багийн хэмжээнд жилд нийт 220.5 тонн сайжруулсан түлш хэрэглэсэн гэсэн судалгаа гарсан. | 2024.01.02<br>2024.03.01 | 100 |
| **Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1.** Жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, батлуулах | Төлөвлөгөөний тоо | 1 | 1 | Жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилт, 40 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 3.2.** Хугацаатай үүрэг даалгавар, тайлан мэдээ, албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлэх, тэдгээрийг | Тухай бүр хугацаанд нь хүргүүлсэн хувиар | 100 | 100 | Хугацаатай албан бичгийн тоо 42 байгаа бөгөөд хариуг хугацаа хоцроолгүй холбогдох мэргэжилтэн, албан байгууллагад хүргүүлж, ажилласан. Үүнээс Цагдаагийн газрын Мөрдөгчийн мэдэгдэл 7, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас 5 судалгаа, ГБХЗХГ-аас 2, Аймгийн Засаг даргын Тамгын газраас 8, Сумын Засаг | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

82

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартын дагуу боловсруулах */АЗД-аас СЗД-тай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 1.1.8, АБТодорхойлолт 4.3 дахь заалт/* | | | | даргын Тамгын газраас 11, бусад байгууллагуудаас 9 хариутай бичиг ирсэн. | | |
| | | Албан бичгийн боловсруулалтад ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Стандарт хэмжилзүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS5140-1:2021 баримт бичгийн стандартыг мөрдөж ажилласан хувиар | 100 | 100 | Мэдээ, тайлан, судалгаа, төлөвлөгөө, удирдамж, илтгэх хуудас зэрэг албан бичгийн боловсруулалтад ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Стандарт хэмжилзүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS5140-1:2021 баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллаж байна.<br>Тайлант онд Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Албан хэрэг хөтлөлт" сургалтад хамрагдсан. Сумын ЗДТГ-с зохион байгуулсан Үндэсний бичгээр албан бичиг боловсруулах сургалтад хамрагдсан. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 3. | **Арга хэмжээ 3.3.** Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг хугацаанд нь дээд шатны байгууллагад уламжилж, бүртгэлийн дэвтэрт бүртгэсэн байх, холбогдох мэдээ тайланг хугацаанд нь өгөх */АЗД-аас СЗД-тай 2023 онд байгуулсан хамтран* | Алдарт эхийн одон, төрийн дээд одон медалиар шагнуулах иргэдийн материал, өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй | 100 | 100 | Алдарт эхийн 2 дугаар зэргийн одон авах эрх үүссэн 10 эхийн судалгааг гаргаж, зар мэдээг хүргэж холбогдох материалуудыг бүрдүүлэн холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажилласан..<br>2024.06.01-ний өдөр аймгийн Хөгжимт драмын театрт 8 эхэд аймаг, сумын удирдлагууд Алдарт эх одонг гардуулсан. 2 эх эрүүл мэндийн шалтгаанаар дараа нь авсан. Төрийн одон медаль хүсэж, материал ирүүлсэн 16 иргэний материалыг журмын дагуу бүрдүүлэн сумын ЗДТГ-т хүргүүлсэн. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | *ажиллах гэрээний 1.1.9, АБТодорхойлолт 4.3 дахь заалт/* | уламжилж, хариу өгсөн хувиар | | | | | |
| | | Өргөдөл гомдлын мэдээг улирал тутам өгсөн тоогоор | 4 | 4 | Нийт 226 өргөдөл, гомдол ирснээс түлээ нүүрсний дэмжлэг хүссэн 58, эко 00 төсөлд хамрагдахыг хүссэн 42, эмчилгээний зардалд дэмжлэг хүссэн 35, шагнал хүссэн 16, эко 00 төсөлтэй холбоотой гомдол 12, төсөлд хамрагдахыг хүссэн 10, алдарт эхийн одон хүссэн 10, амьдрах орчны бохирдол хог, нохойтой холбогдолтой 33, ажилд орохыг хүссэн 6, гэр хүссэн 3 хүсэлт байна. Үүнээс 207 өргөдөл гомдлыг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлүүлж, 19-ийг шийдвэрлэж хариу өгсөн. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 4. | **Арга хэмжээ 3.4.** Аймаг, сумын удирдлагаас ирүүлсэн тогтоол, захирамжийг хяналтад авах, үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах */АБТодорхойлолт 4.3 дахь заалт/* | Тогтоол, шийдвэрийг хяналтад авч биелэлтийг тайлагнасан тоогоор | - | - | Тайлант онд хууль тогтоомж лавламжийн санд нийт 75 эрх зүйн акт, үүнээс шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо 14, эрх зүйн лавлагаа мэдээлэл өгсөн иргэдийн тоо 698, боловсруулсан гарын авлага 10, бусад мэдээллийн хэрэгслээр сурталчилсан 72 байна. Эрх зүйн мэдээлэл лавлагааны дийлэнх хувийг Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Малын хөлийн албан татварын тухай хууль, Иргэний хууль, цахим шилжилттэй холбоотой иргэдийн цахим ур чадвар хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлийн зөвлөгөө мэдээлэл бусад хууль тогтоомжууд эзэлж байна. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | "Амар тайван Өвөрхангай" дэд хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар *АЗДҮАХ-ийн 3.3.3.1 дэх заалт* | 95 | 100 | Аймгийн ИТХ-ын 2021 оны 30 дугаар тогтоолоор баталсан "Амар тайван Өвөрхангай" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 3 зорилт 15 арга хэмжээтэйгээр төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан. Хөтөлбөрийн биелэлт 94 хувьтай. | 2024.01.02<br>2024.12.31 | 94 |
| 5. | **Арга хэмжээ 3.5.** Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг хууль тогтоомж, заавар | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримтыг бүрэн | | 5 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивлах баримтуудыг цэгцлэн 2024 3 сарын 28-нд өдөр 7 хавтас бүхий хадгаламжийн нэгж үүсгэн архив бичиг хэргийн эрхлэгчид хугацаанд хүлээлгэн өгсөн. | 2024.01.02<br>2024.03.28 | 100 |

84

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | журмын дагуу хөтлөн явуулж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримтыг бүрдүүлж архивлах. */АБТодорхойлолт 4.3 дахь заалт/* | хөтлөх. Архивын баримтыг бүрэн бүрдэлтэй нь хугацаанд байгууллагын архивд хүлээлгэн өгсөн тоогоор | 5 | | | | |
| 6. | **Арга хэмжээ 3.6.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 95 | 100 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг 3 зорилт, 13 арга хэмжээний хүрээнд төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тайланг заасан хугацаанд нь сумын ИТХ-д өгсөн. Төлөвлөгөөний биелэлт 95 хувьтай. | 2024.01.02 2024.12.31 | 95 |
| 7. | **Арга хэмжээ 3.7.** Аймаг, сумын зорилтот жилийн ажлын хүрээнд багт хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, үр дүнг тооцох | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 96 | 100 | “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” аймгийн зорилтот жилийн төлөвлөгөөг 3 зорилт 10 арга хэмжээтэйгээ боловсруулж хэрэгжилтийг хангаж ажилласан. Багийн зорилтот жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 93,2 хувьтай хэрэгжсэн. | 2024.01.02 2024.12.31 | 93 |
| 8. | **Арга хэмжээ 3.8.** Төрийн байгууллагын веб сайтад тавигдах мэдээг улирал бүр гарган, холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх, ажлын жагсаалтыг сар бүр хүргүүлэх | Веб сайтад байршуулах мэдээг гарган хүргүүлсэн тоо | 4 | 4 | Arvaihkeer.gov.mn цахим хуудсанд багийн ажлын албанаас зохион байгуулсан үйл ажиллагаа, ажлын тайлан мэдээг файлаар Хэвлэл мэдээллийн ажилтанд мэргэжилтэнд улирал тутам хүргүүлж ажилласан. | 2024.01.02 2024.12.31 | 100 |
| | | Сар бүрийн ажлын жагсаалтыг хугацаанд нь хүргүүлсэн тоо | 12 | 12 | Багийн ажлын албанаас тухайн сард хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг тогтоосон хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн ажилласан. | 2024.01.02 2024.12.31 | 100 |
| 9. | **Арга хэмжээ 3.9.** Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, байгууллагад | Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй бүртгэгдээгүй | - | Ёс зүйн зөрчилгүй ажилласан байх | Байгууллагын удирдлага болон нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь хэрэгжүүлэн, ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй бүртгэгдээгүй ажилласан. | 2024.01.02 2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мөрдөгдөж буй дүрэм журам, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй ажилласан байх | ажилласан байх Зөрчлийн тоогоор | | | | | |
| 10. | **Арга хэмжээ 3.10.** Байгууллагаас зохион байгуулсан цаг үеийн холбогдолтой, нэмэлт үйл ажиллагаанд идэвхтэй оролцох. */АБТодорхойлолт 3.4 дэх заалт/* | Оролцсон арга хэмжээний тоогоор | - | Арга хэмжээний тоо | "Мөсний баяр 2024" арга хэмжээнд байгууллагаа төлөөлөн оролцсон.<br>Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зарласан "Хүмүүн бичигтэн" аяны хүрээнд зохион байгуулсан Монгол бичгийн сургалтад хамрагдаж сертификат авсан.<br>Байгууллагын аварга шалгаруулах волейболын тэмцээнд оролцож, 3 дугаар байрт шалгарсан. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ):**

| д/д | Нэмэлт үүрэг, даалгавар | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхлэсэн дууссан огноо | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин, биелэлт | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Сонгуулийн хэсгийн хороонд ажиллах | Сонгуулийн хэсгийн хорооны ажилд туслалцаа үзүүлж ажилласан тоогоор | - | 2 | 2024 оны УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулд хэсгийн хорооны гишүүнээр ажилласан. | 2024.01.02<br>2024.10.11 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 2.** Эрүүл мэндийн даатгал төлөөгүйн улмаас эрт илрүүлэг, үзлэг, оношилгоонд хамрагдаагүй иргэдийн судалгаа гаргах | Судалгааг үнэн зөв гаргаж, заасан хугацаанд хүргүүлсэн тоогоор | - | 1 | Өлзийт 4 дүгээр багийн 19-с дээш насны бүх иргэнийг emd.gov.mn системээр шүүж, эрүүл мэндийн даатгал төлөөгүйн улмаас эрт илрүүлэг, үзлэг, оношилгоонд хамрагдаагүй 336 иргэний судалгааг гарган, 4 дүгээр сарын 24-нд холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажилласан. | 2024.01.02<br>2024.04.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | **Арга хэмжээ 3.** ХАӨМС-ийн хаягийг Улсын бүртгэлийн хаягийн мэдээллийн санд суурилан хөгжүүлэх зорилгоор хаягийг тулгаж, зөрүүтэй байдлыг тогтоох | Судалгааг үнэн зөв гаргаж, заасан хугацаанд хүргүүлсэн тоогоор | - | 1 | Өлзийт 4 дүгээр багийн 831 улсын бүртгэлийн буюу хуучин хаягийн дагуу тухайн хаягт бүртгэлтэй өрхүүдийн өрхийн бүртгэлийн дугаарыг ХАӨМС программаас шүүж, зөрүүтэй байдлыг тогтоон маягтыг бөглөж, судалгааг гаргасан. | 2024.01.02<br>2024.06.25 | 100 |
| 4. | **Арга хэмжээ 4.** Аймгийн Онцгой байдлын газарт аймгийн шуурхай штабт жижүүрт гарах | Байгууллагаас гаргасан хуваарийн дагуу шуурхай штабт жижүүрт гарч, штабын даргаас өгсөн үүргийг хэрэгжүүлэх | - | 1 | 2023-2024 оны өвөлжилт хүндэрч төмөр болон цагаан зуд болсонтой холбогдуулан аймгийн Онцгой байдлын газарт аймгийн Шуурхай штабт 1 удаа жижүүрт гарч, сумдаас хаагдсан зам даваа, өвөлжөө, хаваржааны хайс хашаа цасанд дарагдсан малчдын судалгаа болон шар усны үерт өртөж болзошгүй өрхийн судалгааг авч, нэгтгэн тухайн өдрийн Шуурхай штабын даргад хүлээлгэн өгсөн. | 2024.01.02<br>2024.03.25 | 100 |
| 5. | **Арга хэмжээ 5.** Хаягийн орон зайн мэдээллийн сангийн шинэчлэл | Хуучин болон шинэ хаягийг үнэн зөв гаргаж, заасан хугацаанд нь хаяг бүртгэх системд шивж оруулах | - | 1 | ХАӨМС шинэчлэлтэд ашиглах хаягийн орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх судалгаа, тодруулгыг хаяг бүртгэх системд хуучин болон шинэ хаягаар оруулж бүртгэн, зурагт ороогүй шинэ хашаа, гудамжийг зурж, одоогийн хаягийг оруулж, заасан хугацаанд нь бүрэн дуусгаж ажилласан. | 2024.01.02<br>2024.10.25 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээ**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхлэсэн дуусcан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин, биелэлт | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Худалдан авах ажиллагааны А3 сургалтад хамрагдана | Сертификат авсан байх | - | - | Худалдан авах ажиллагааны А3 сургалтад хамрагдаж, сертификат авсан. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 2.** Компьютерийн өргөн хэрэглээний | Суралцсан кредит цаг | | | “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жилийн хүрээнд Арвайхээр сумын ЗДТГ-аас зохион байгуулсан “Төрийн албан хаагчдын цахим ур чадвар, мэдээллийн | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | программ хангамж, цахим хөгжүүлэлт чиглэлээр 5-7 хоногийн хугацаатай 1 удаагийн сургалтад хамрагдана | | - | 3-аас доошгүй | аюулгүй байдлыг сайжруулах" 2 удаагийн 11 цагийн сургалтад хамрагдаж, сургагч багш батламж авсан. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ӨЛЗИЙТ 4 ДҮГЭЭР БАГИЙН
ЗОХИОН БАЙГУУЛАГЧ ................................ /Ш.БОЛОРЧУЛУУН/ 2024.11.24